



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 4/60

Дэлгэрхаан сум

Шувууны хиймэл үүр суулт хийхэд
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолын 3.6.4 дэх заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас төсөвлөсөн ажлын төлөвлөгөөний дагуу зарцуулж, Амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, орчинг сайжруулах зорилгоор шувууны хиймэл үүрийг нэмэгдүүлэх ажилд зардал гаргасугай.

2.Шувууны хиймэл үүр хийх ажилд шаардлагатай 1,380,000 (нэг сая гурван зуун наян мянга) төгрөгнөөс эхний санхүүжилтээр 70 хувь буюу 966,000 (есөн зуун жаран зургаан мянга) төгрөг, ажил гүйцэтгэж ажлын хэсэгт хүлээлгэн тайлангаар баталгаажсаны дараа 30 хувь буюу 414,000 (дөрвөн зуун арван дөрвөн мянга) төгрөгийг "Шилхэнцэгийн Оюут чулуу" хязгаарлагдмал хувьцаат компаний дансанд шилжүүлсүгэй.

3.Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар хийгдэж буй судалгаа хийх ажлыг чанартай зохион байгуулж, ажлын тайлан, судалгааг фото зургаар баталгаажуулж гаргаж ирүүлэхийг "Шилхэнцэгийн Оюут чулуу" хязгаарлагдмал хувьцаат компаний захирал (Д.Эрдэнэчулуун)-д, хяналт тавьж ажиллахыг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (У.Ариунтуяа), байгаль хамгаалагч (Х.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

4.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Анхцэцэг)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо) нарт даалгасугай.

ДАРГА Б.ЭНХ-АМГАЛАН



2328010120

دانشگاه سیدالشهدا قم
 دانشکده معارف اسلامی



تاریخ: ...

شماره: ...

تاریخ: ...

دانشگاه و راجع به ...
 موضوع: ...

اینجانب بصورت ...
 ...
 ...

...
 ...
 ...

...
 ...
 ...

...
 ...
 ...

...
 ...
 ...

...
 ...

